



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/У67

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 157 дугаар
цэцэрлэгийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 3,109,900.0 /гурван сая нэг зуун есөн мянга есөн зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэг /Д.Бурмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг авахыг Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэг /Д.Бурмаа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001394

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 15 өдрийн 44 дугаар тушаалын хавсралт

1119322485-4,3576583

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалт анд авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Эх үүсвэр		
								Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр	
1	Сургалтын хэрэглэгдэхүүний тавиур	ДСП	3 тавиуртай /шар ногоон өнгийн/	2019	сайн	ком	1	750,000	750,000			
2	Хувцасны шүүгээ	ДСП	4 хаалгатай /саарал өнгөтэй/	2019	сайн	ш	1	365,000	365,000	Эцэг эхчүүд		
3	Хувцасны шүүгээ	ДСП	2 хаалгатай /шаргал өнгөтэй/	2019	сайн	ш	1	500,000	500,000		Хандив	
								1,615,000	1,615,000			
Тавилга эд хогшлын дүн												
1	Өнгөт принтер	Epson L4168	Өнгөт	2019	сайн	ш	1	580,000	580,000	Оюуны хөгжлийг дэмжих академи		
2	Зурагт	Elko	32 инч	2019	сайн			330,000	330,000			
3	Хөгжим	Panasonic	DVD	2019	сайн	ш	1	584,900	584,900	Эцэг эхчүүд		
								1,494,900	1,494,900			
								3,109,900	3,109,900			
Тоног төхөөрөмжийн дүн												
Нийт бүртгэх дүн												